



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Чинбүрэн

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Э.Батшугар

-Улсын Их Хурлын гишүүн

Н.Ганибал

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Идэрбат

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Саранчимэг

-Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжилтэн, албан хаагчийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг (Ж.Чинбүрэн)-т зөвшөөрсүгэй.

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Э.БАТШУГАР